



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2023.10.27 № 31

Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн  
талаар

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар хийсэн мэдээлэлд миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийг төлөөлж, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс иргэдээс ирүүлсэн асуултыг асууж, хариулт авсан.

Энэхүү мэдээллийн үеэр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн Тавантолгойн дулааны цахилгаан станцын төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2023 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах талаар мэдэгдсэн.

Гэвч Тавантолгойн дулааны цахилгаан станцын төслийн ажил өнөөг хүртэл шийдэгдээгүй, тендер шалгаруулалтад урьд өмнө цахилгаан станц барьж, ашиглалтад оруулсан туршлага байхгүй Камбож Улсын компани урьдчилсан байдлаар шалгарсан тухай мэдээллийг иргэд, салбарын мэргэжилтнүүдээс ирүүлж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад хүлээлгэн өгөх төслийн ажлын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
2. Тавантолгойн дулааны цахилгаан станцын төслийн ажил яагаад өнөөдрийг хүртэл хойшилсон, хэзээ бүрэн ашиглалтад орохоор төлөвлөж байгаа, энэ талаар хэрэгжүүлж буй ажлын талаар;

2023000114

3. Тус төслийн тендер шалгаруулалтын талаар болон дээр дурдсан Камбож Улсын компани урьдчилсан байдлаар шалгарсан гэх мэдээлэл үнэн бодитой эсэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

4. Уг станц ашиглалтад орсноор Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ард иргэдэд үзүүлэх үр өгөөжийн талаарх мэдээлэл зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье. Асуулгын хариуг мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ж.БАТСУУРЬ

2023080114